

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны 02 сарын
01-ны өдөр



Дугаар 1/354/10/19.....

Улаанбаатар хот

**Шалгуур үзүүлэлт шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Шалгуур үзүүлэлтийн дагуу тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд ур чадварын нэмэгдлийн санд багтаан багш, зарим албан тушаалтанд нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулахыг холбогдох төсвийн захирагч наарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн “Шалгуур үзүүлэлт батлах тухай” 362/112/183 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Сангийн сайдын
2021 оны 1 дүгээр сарын 1.-ны өдрийн
1/35 / 1/10 / 9 дугаар
хамтарсан тушаалын хавсралт

**ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ,
ЗАРИМ АЛБАН ТУШААЛТАНД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ
ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлд хамаарах цэцэрлэгийн багш, туслах багш, арга зүйч, эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн багш, туслах багш, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, сургалтын менежер, захидал (цаашид “багш, ажилтан” гэх) нарт ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү шалгуур үзүүлэлтийг мөрдөнө.

2. Ур чадварын нэмэгдлийг албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг, багшлахуй, суралцахуйн үйлийг бүтээлчээр хэрэгжүүлж онцгой амжилт гаргасан, шинийг санаачлан хэрэгжүүлж үр дунд хүрсэн, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн багш, ажилтанд энэхүү баримт бичгийн 3, 4, 5-д заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан олгоно.

3. Багш, ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана. Үүнд:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний биелэлт нь “Хангалттай” түвшинд үнэлэгдсэн байх;

3.2. Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх;

3.3. Авлига албан тушаалын болон санхүүгийн зөрчилгүй байх;

3.4. Цэцэрлэг, сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчил гараагүй байх;

4. Энэ шалгуур үзүүлэлтийн 3-т заасан нийтлэг шалгуурыг хангасан ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус үнэлнэ.

4.1. Ерөнхий боловсролын сургуулийн захидал

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Манлайлал, менежментийн ур чадвар	Багш, ажилтны үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөл, суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бурдүүлж, үр дунд хүрсэн байдал	50
	Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт, багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал /суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтны сэтгэл ханамж/	
	Багш, ажилтанд зөвлөн туслах ажлын арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн байдал	
Мэргэжил, арга зүйн хөгжил дэмжлэг	Багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн	50

	Суралцагчийн төлөвшил, хандлагад гарсан ахиц өөрчлөлт	
	Суралцагчдын сурлагын амжилтад гарсан ахиц, амжилт	

4.2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжил, арга зүйн хөгжил	Багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ур чадвараа дээшлүүлсэн байдал	60
	Сургуулийн орчинд сэтгэл зүйн таатай орчин, эерэг уур амьсгал бүрдүүлж, харилцааны зөв дадал хэвшил төлөвшүүлэх чиглэлээр багш, ажилтныг манлайлан ажиллаж үр дүнд хүрсэн байдал	
	Багшид зөвлөн туслах ажлын арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн байдал	
Багшийг хөгжүүлэх үйл ажиллагааны ахиц амжилт	Багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг тэдний хэрэгцээнд нийцүүлэн үр дүнтэй зохион байгуулсан байдал	40
	Суралцагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн багшлах арга зүйгээр багшид дэмжлэг үзүүлж үр дүнд хүрсэн байдал (Суралцагчийн сурлагын амжилт, хөгжил, төлөвшилд гарсан ахиц)	

4.3. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Манлайлал, онол арга зүйн мэдлэг чадвар	Суралцагчид хүндрэл бэрхшээл, үүсэхээс урьдчилан сэргийлэх, суралцахад тохиолдсон бэрхшээл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар өөрийгөө хөгжүүлсэн байдал	50
	Сургуулийн орчинд сэтгэл зүйн таатай орчин, эерэг уур амьсгал бүрдүүлж, харилцааны зөв дадал хэвшил төлөвшүүлэх чиглэлээр багш, ажилтныг манлайлан ажиллаж үр дүнд хүрсэн байдал	
	Суралцагчад нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлж буй ажлын арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн байдал	
Нийгмийн ажлын үйлчилгээний чанар, үр дүн	Хүүхдийн эрхийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хүүхдэд учирсан хучирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг шийдвэрлэж үр дүнд хүрсэн байдал	50
	Багш, эцэг эх, суралцагчдын нийгэм, сэтгэл зүйн байдлыг удирдан чиглүүлсэн ажлын үр дүн Хичээлээс гадуурх сургалтын ажлыг тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнд хүрсэн байдал	

4.4. Ерөнхий боловсролын сургуулийн багш

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжлийн үр чадвар, тасралтгүй хөгжил	Багш мэргэжлийн онол арга зүйн мэдлэг, үр чадвараа тасралтгүй дээшлүүлсэн байдал, үр дүн	40
	Багшлах арга туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байдал	

Багшлах ажлын үр дүн	Мэргэжлийн бүлгийн хөгжүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлж, үр дүнд хүрсэн байдал	60
	Суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байдал (Суралцагчдын сурлагын амжилт, хөгжил, төлөвшилд гарсан ахиц)	
	Багшлах ажлын онол, арга зүйн чиглэлээр хийсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний үр дүн	
	Суралцагчийн төлөвшил, хандлага, сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байдал	

4.5. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын багш

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжлийн үр чадвар	Хүүхдийн аюулгүй, эрүүл орчинд суралцах, амьдрах үйлчилгээний чанар, үр дүн	20
	Суралцагч бүрийн хэрэгцээг тооцсон хөгжүүлэх, төлөвшүүлэх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, үр дүн	20
	Суралцагчийн төлөвшил, хандлага, сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байдал	20
	Сургалт, хүмүүжлийн ажилд нэвтрүүлсэн шинэлэг ажил, үйлчилгээний арга барил, эв дүй	20
	Хүүхдэд эрүүл ахуйн зөв дадалд хэвшүүлэх талаар хүүхэд, багш, эцэг эхтэй хамтарч ажилласан байдал /суралцагч, эцэг эхийн сэтгэл ханамж/	20

4.6. Ерөнхий боловсролын сургуулийн туслах багш

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжлийн үр чадвар	Суралцагчийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх ажлын чанар, үр дүн	25
	Хүүхдийн хэрэгцээг тооцсон хөгжүүлэх болон хичээл, сургалтын үйл ажиллагаанд үзүүлсэн дэмжлэг, үр дүн	25
	Нэвтрүүлсэн шинэлэг ажил, үйлчилгээний чанар, үр дүн	25
	Хүүхдэд эрүүл ахуйн зөв дадал хэвшүүлэх талаар хүүхэд, багш, эцэг эхтэй хамтарч ажилласан байдал /эцэг эхийн сэтгэл ханамж/	25

5. Энэ шалгуур үзүүлэлтийн 3-д заасан нийтлэг шалгуурыг хангасан цэцэрлэгийн багш, ажилтны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус үнэлнэ.

5.1. Цэцэрлэгийн эрхлэгч

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь

Манлайлал, менежментийн ур чадвар	Багш, ажилтны үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөл, хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдүүлж, үр дүнд хүрсэн байдал	60
	Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт, багш ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал /Эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтны сэтгэл ханамж/	
	Багш, ажилтанд зөвлөн туслах ажлын арга туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байдал	
Мэргэжил, арга зүйн хөгжил дэмжлэг	Багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн	40
	Хүүхдийн хөгжил, төлөвшилд гарсан ахиц	

5.2. Цэцэрлэгийн арга зүйч

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжил, арга зүйн хөгжил	Багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үр чадвараа дээшлүүлсэн байдал	60
	Цэцэрлэгт сэтгэл зүйн таатай орчин, эерэг уур амьсгал бүрдүүлж, харилцааны зөв дадал хэвшил төлөвшүүлэх чиглэлээр багш, ажилтныг манлайлан ажиллаж үр дунд хүрсэн байдал	
	Багшид зөвлөн туслах ажлын арга туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байдал	
Багшийг хөгжүүлэх үйл ажиллагааны ахиц	Багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг тэдний хэрэгцээнд нийцүүлэн үр дүнтэй зохион байгуулсан байдал	40
	Хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн багшах арга зүйгээр багшид дэмжлэг үзүүлж үр дунд хүрсэн байдал (Хүүхдийн хөгжил, төлөвшилд гарсан ахиц)	

5.3. Цэцэрлэгийн багш

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжил	Багш мэргэжлийн онол арга зүйн мэдлэг, үр чадвараа тасралтгүй дээшлүүлсэн байдал, үр дүн	40
	Багшах арга туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байдал	
Багшах ажлын үр дүн	Мэргэжлийн бүлгийн хөгжүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлж, үр дунд хүрсэн байдал	60
	Хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, үр дунд хүрсэн байдал (Хүүхдийн хөгжил, төлөвшилд гарсан ахиц)	
	Багшах ажлын онол, арга зүйн чиглэлээр хийсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний үр дүн	

5.4. Цэцэрлэгийн туслах багш

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь

Мэргэжлийн ур чадвар	Хүүхдийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх ажлын чанар, үр дүн	25
	Хүүхдийн хэрэгцээг тооцсон хөгжүүлэх, төлөвшүүлэх ажилд үзүүлсэн дэмжлэг, үр дүн	25
	Нэвтрүүлсэн шинэлэг ажил, үйлчилгээний чанар, үр дүн	25
	Хүүхдэд эрүүл ахуйн зөв дадал хэвшүүлэх талаар хүүхэд, багш, эцэг эхтэй хамтарч ажилласан байдал /эцэг эхийн сэтгэл ханамж/	25

6. Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно.

7. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60,0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно.

8. Багш, ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ.

9. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн ур чадварыг үнэлж дүгнэх ажлын хэсэг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ.

- 9.1. Боловсролын асуудал хариуцсан орон нутгийн нэгжээс 2 хүн;
- 9.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн 1 хүн;
- 9.3. Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн төлөөлөл 1 хүн;
- 9.4. Эцэг эх, олон нийтийн төлөөлөл 1 хүн;

10. Энэхүү баримт бичгийн 4, 5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60,0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын тувшинийг харгалzan нэмэгдлийг дараах хувиар тогтоосно.

Цэцэрлэг, сургуулийн тувшинд амжилт гаргасан	Сум, дүүргийн тувшинд амжилт гаргасан	Аймаг, нийслэлийн тувшинд амжилт гаргасан	Улс, бүс, олон улсын амжилт тувшинд гаргасан
10%	15%	20%	25%

11. Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

12. Ур чадварын нэмэгдлийг тухайн багш, ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл (эрүүл мэнд, амьдрал, ахуйн нөхцөл, байдал)-ийг харгалzan олгохыг хориглоно.
